# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

# ЗОХИЦУУЛАЛТТАЙ САЛБАРЫН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН 2023 ОН

(ДААТГАГЧ, ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ)

**Гүйцэтгэсэн:**

А.Авир, дарга
Л.Мөнхзаяа, ахлах референт
Ж.Лхагвамядаг, мэргэжилтэн

# ЗОХИЦУУЛАЛТТАЙ САЛБАРУУДЫН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ 2023 ОНЫ ТАЙЛАН

(ДААТГАГЧ, ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ)

## ҮЙЛ ЯВЦЫН ӨРНӨЛ

**2006 он**

Монгол Улсын Их хурлаас “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийг баталж, компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох бүрэн эрхийг тус Хороонд олгов.

**2007 он**

“Монгол компанийн засаглалын кодекс”-ийг Хороо анх удаа батлав.

**2014 он**

“Компанийн засаглалын кодекс”-т нэмэлт, өөрчлөлт оров.

**2022.03.23**

Хорооны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийн шинэчилсэн найруулга батлагдлаа. Шинэчилсэн кодексийн хавсралтаар олон улсад түгээмэл ашиглагддаг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмаар үнэлгээний аргачлал бүхий тайлангийн маягт болон компанийн дотооддоо баталж, мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журмын заавpын үлгэрчилсэн загваруудыг батлав.

**2022.04.15**

Кодекс “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл”-д бүртгэгдэж, эрх зүйн мэдээллийн www.legalinfo.mn нэгдсэн системд байршсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ба нээлттэй хувьцаат компаниудаас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) болон хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК)-ууд дагаж мөрдөх үүргийг хүлээв.

**2022.04.20**

Хорооны зохицуулалтын 3 салбарын нийт зохицуулалттай этгээдийн ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагыг оролцуулан кодексийн хэрэгжилтийн үнэлгээг хэрхэн тайлагнах талаар сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

**2022.05.16**

Зохицуулалтын 3 салбарын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх ажлыг эхлүүлэв.

**2022.06.22**

Хорооны даргын 2022 оны 336 дугаар тушаалаар “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж”-ийг баталж, компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх нэгдсэн зохион байгуулалт, зах зээлд оролцогч талуудын баримтлах зарчим, чиг үүргийг тодорхойлов.

**2022.12.30**

Хорооны зохицуулалтын 3 салбарын нийт 116 зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэн салбар тус бүрийн зэрэглэлийг тогтоож, нийтэд мэдээлэв. Үнэлгээг хянан баталгаажуулахад, 2022 оны 8 дугаар сарын байдлаар кодексийн хэрэгжилтийн анхны буюу нөхцөл байдлын үнэлгээ 55.3 хувийн гүйцэтгэлтэй байсан бол Хорооноос үнэлгээний тайлангийн хариугаар компани тус бүрд зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, мөн оны 12 дугаар сард биелэлтийг нь тооцсон давтан үнэлгээгээр зохицуулалттай нийт 3 салбарын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ дунджаар 16.4 хувиар өсөв.

**2023.06.30**

Нийт 124 зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэн, компани тус бүрд чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

**2023.12.28**

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн давтан ирүүлсэн нийт 81 компанийн тайланг хянан баталгаажуулахад, 2023 оны эцсийн байдлаар дундаж үнэлгээ өмнөх оныхоос 26.4 хувиар дээшилсэн ахиц дэвшлийг үзүүлэв.

## 1. СУДАЛГААНЫ ТАЛААР

Компанийн засаглалыг нэвтрүүлэх нь бизнесийн үйл ажиллагааны урт хугацааны өгөөжийг хангах төдийгүй хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд суурилсан шударга, нээлттэй зах зээлийн орчин бүрдэхэд эергээр нөлөөлдөг тул нийгэмд ач холбогдолтой энэ сэдвийг онцгойлон анхаарч, тогтмол хөгжүүлэх шаардлагатай.

Олон улсын практикийн дагуу компанийн засаглалын чанар, кодексийн хэрэгжилтийг үнэлэхдээ эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн зэрэглэл тогтоох аргыг ашиглав.

Компанийн засаглалын зэрэглэл нь тухайн компанийн үйл ажиллагаанд эрсдэлийн дүн шинжилгээ хийх мэдээлэл болж өгснөөр хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрсдэлгүй шийдвэр гаргалтад эергээр нөлөөлнө.

## 2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

- Кодексийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлж нэгдсэн тайлан боловсруулах;
- компанийн засаглалын хандлага, учирч болох эрсдэлийг тодорхойлох;
- хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч эрсдэлийн үнэлгээ хийж, шийдвэр гаргах засаглалын үзүүлэлтийг бий болгох;
- засаглалаар тэргүүлэгчдийг тодруулах, компанийн засаглалын зэрэглэл тогтоох;
- зохицуулалттай этгээд өөрийн засаглалыг салбартаа харьцуулах, сайжруулахад чиг баримжаа болох компанийн засаглалын жишгийг тодорхойлох;
- хууль тогтоомж болон компанийн баталсан дотооддоо дагаж мөрдөх дүрэм, журмын эрх зүйн орчныг оновчтой болгож, сайжруулах;
- хугацааны цуваа хэлбэрээр статистик мэдээллийг үүсгэх.

## 3. АРГАЧЛАЛ

Судалгаа нь "Компанийн засаглалын кодекс"-ийн 36 зүйлийн хэрэгжилтийн асуумжаар 2023 оны гүйцэтгэсэн нийт 124 зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ийн эхний болон 81 давтан үнэлгээний тайлангууд, үүнтэй зэрэгцэн Хорооноос зохион байгуулсан судалгааны үр дүнд суурилсан.

### **3.1.** СУДАЛГААНЫ ГОЛЛОХ СЭДЭВ:

**а. Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагаа, бүтэц, бүрэлдэхүүн.**

**б. дотоод эрх зүйн зохицуулалтын ил тод байдал (цахим хуудасны шинэчлэл):**

- бодлогын баримт бичиг;
- ёс зүйн дүрэм;
- компанийн дүрэм, дотоод үйл ажиллагааны журам;
- мэдээллийн ил тод байдал, тайлагнал, комплайнсын хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны журам, заавар;
- компанийн эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр.

**в. хамгийн сайн болон сул хэрэгжсэн засаглалын үзүүлэлтүүд.**

### **3.2.** СУДАЛГААНД ХАМРАГДАГСАД:

Кодексийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн зохицуулалттай этгээд.

а. Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс нийт 124 зохицуулалттай этгээдийн эхний үнэлгээний тайланг хянан баталгаажуулан, эдгээр тайлангийн хариугаар хугацаатай үүрэг даалгавар бүхий албан тоотыг хүргүүлсэн ба 81 давтан үнэлгээний тайланг кодексийн хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, ахиц дэвшлийг үнэлэв.

б. Компаниудын ирүүлсэн зайны үнэлгээг хавсаргасан нотлох баримтад үндэслэн үнэлгээний хяналтын оноо болон хувиар нэгдсэн дүнг тооцов.

в. Үнэлгээний нэгдсэн дүнг үндэслэн компани тус бүрд тухайлсан зөвлөмж, чиглэл хүргүүлэн тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлов.

Компанийн үнэлгээний нэгдсэн дүн нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэл хийхтэй холбоотойгоор Хорооноос холбогдох шийдвэр гаргах, компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон эрх зүйн орчныг боловсронгуй, оновчтой болгох чиглэлд дүн шинжилгээ хийх, мөн компанийн засаглалын зэрэглэлийн нэгдсэн судалгааг гарган нийтлэх, мэдээллийн зорилгоор ашиглана.

# 4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

*ДҮРСЛЭЛ 1. "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗАЙНЫ ҮНЭЛГЭЭНД СУУРИЛСАН ХУГАЦААТАЙ ЧИГЛЭЛ, ҮҮРГИЙН ДАГУУ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ:*




*Шигтгээ 1:*

*Давтан үнэлгээгээр нийт 81 зохицуулалттай этгээдийн "Компанийн засаглалын кодекс"–ийн хэрэгжилтийн үнэлгээ дунджаар 26.4 хувиар өсөв.*

*Шигтгээ 2:*

*Даатгагч 26.8, ББСБ 24.5, ХОМК 27.7 хувиар тус тус өсөлтийг харуулав.*

*ДҮРСЛЭЛ 2. "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ:*



*ДҮРСЛЭЛ 3. ЦАХИМ ХУУДСАНДАА ИЛ БОЛГОСОН МЭДЭЭЛЭЛ:*




## 5. ДААТГАГЧИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

*ДҮРСЛЭЛ 4. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:*




*Шигтгээ 3:*

*Даатгалын 16 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ **26.8** хувиар өссөн үзүүлэлттэй байна.*

*ДҮРСЛЭЛ 5. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:*




*Шигтгээ 4:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн **5–9** гишүүнтэй, үүнээс **30.6%** нь хараат бус гишүүд байна.*

*Шигтгээ 5:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн **36.3** хувийг эмэгтэй гишүүд эзэлж байна.*

*ДҮРСЛЭЛ 6. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:*




*ДҮРСЛЭЛ 7. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):*




*ДҮРСЛЭЛ 8. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*



*ДҮРСЛЭЛ 9. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*







*ДҮРСЛЭЛ 10. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:*




*Шигтгээ 6:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр дунджаар* *3-5* *гишүүнтэй.*

*ДҮРСЛЭЛ 11. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:*



*Шигтгээ 7:*

*2023 оны байдлаар 94.0% нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаа өөрийн цахим хуудсандаа байршуулсан.*

*Шигтгээ 8:*

*Тайлант хугацаанд 70.0% нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.*

*ДҮРСЛЭЛ 12. ХАМГИЙН САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН КОДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:*

**Хамгийн сайн хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:**

- 96% — ТУЗ-ийн дэргэдэх хороодын бодлого, журмын зохицуулалт
- 95% — Цахим хуудасны хөгжүүлэлт
- 92% — ТУЗ-ийн үйл ажиллагаа, түүний эрх, үүрэг, хариуцлагын журам
- 90% — Ёс зүйн дүрмийн шинэчлэл

**Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:**

- 36% — ТУЗ-ийн гишүүдэд зориулсан чиглүүлэх болон чадваржуулах сургалт
- 34% — Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур
- 12% — ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан
- 8% — ТУЗ-ийн дарга, гишүүдийн ажлын үнэлгээ

## 5.1. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР БАЙР ЭЗЛҮҮЛСЭН ЗЭРЭГЛЭЛ* (*Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодруулав*)

| Байр | Компанийн нэрс | Байр | Компанийн нэрс |
|---|---|---|---|
| 1 | "ПРАКТИКАЛ ДААТГАЛ" ХХК | 8 | "ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ" ХК |
| 2 | "АГУЛА ДААТГАЛ" ХХК | 9 | "НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ" ХХК |
| 3 | "МОНРЕ ДААТГАЛ" ХХК | 10 | "ХААН ДААТГАЛ" ХХК |
| 4 | "ГАН ЗАМ ДААТГАЛ" ХХК | 11 | "АМАР ДААТГАЛ" ХХК |
| 5 | "МӨНХ ДААТГАЛ" ХХК | 12 | "УЛААНБААТАР ХОТЫН ДААТГАЛ" ХХК |
| 6 | "МИГ ДААТГАЛ" ХХК | 13 | "НОМИН ДААТГАЛ" ХХК |
| 7 | "ТЭНГЭР ДААТГАЛ" ХХК | 14 | "МАНДАЛ ЛАЙФ ДААТГАЛ" ХХК |

* *“Ард даатгал” ХК, “Бодь даатгал” ХК, “Мандал даатгал” ХК, “Монгол даатгал” ХК-ийн кодексийн хэрэгжилтийн үнэлгээ “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн кодексийн үнэлгээний тайланд багтсан тул энэхүү зэрэглэлд оруулаагүй болно*

## 6. ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

*ДҮРСЛЭЛ 13. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:*




*Шигтгээ 9:*

*Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч 53 ББСБ–ын кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 24.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.*

*ДҮРСЛЭЛ 14. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:*




*Шигтгээ 10:*

*Төлөөлөн удирдах зөвлөл нь 3–9 хүний бүрэлдэхүүнтэйгээс 22.6% нь хараат бус гишүүд байна.*

*Шигтгээ 11:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 34.8% нь эмэгтэй.*

*ДҮРСЛЭЛ 15. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:*



*ДҮРСЛЭЛ 16. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):*




*ДҮРСЛЭЛ 17. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*




*ДҮРСЛЭЛ 18. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*



*ДҮРСЛЭЛ 19. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:*




*Шигтгээ 12:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 3–5 гишүүнтэй.*

*ДҮРСЛЭЛ 20. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:*




*Шигтгээ 13:*

*2023 оны байдлаар 32.0% нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулсан.*

*Шигтгээ 14:*

*Тайлант хугацаанд 43.0% нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.*

*ДҮРСЛЭЛ 21. ХАМГИЙН САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН КОДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:*

**Хамгийн сайн хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:**

- 94% — ТУЗ-ийн дэргэдэх хороодын бодлого, журмын зохицуулалт
- 93% — ТУЗ-ийн үйл ажиллагаа, түүний эрх, үүрэг, хариуцлагын журам
- 89% — ТУЗ-ийн болон нарийн бичгийн даргын ажлын тайлан
- 88% — Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зохицуулалт

**Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:**

- 34% — ТУЗ-ийн гишүүдэд зориулсан чиглүүлэх болон чадваржуулах сургалт
- 25% — Цахим хуудасны хөгжүүлэлт
- 8% — ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан
- 5% — ТУЗ-ийн дарга, гишүүдийн ажлын үнэлгээ

## 6.1. "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР БАЙР ЭЗЛҮҮЛСЭН ЗЭРЭГЛЭЛ[†] (*Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодруулав*)

| Байр | Компанийн нэрс | Байр | Компанийн нэрс |
|---|---|---|---|
| 1 | "БУЛЛ КАПИТАЛ ББСБ" ХХК | 38 | "ШИЙДЭЛ ФИНАНС ББСБ" ХХК |
| 2 | "МОБИФИНАНС ББСБ" ХХК | 39 | "АШИД КАПИТАЛ ББСБ" ХХК |
| 3 | "НЬЮФОНД ББСБ" ХХК | 40 | "ПРОГРЕСС КАПИТАЛ ББСБ" ХХК |
| 4 | "ҮЙЗЭН-ИВЭЭЛТ ББСБ" ХХК | 41 | "СИ И СИ ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК |
| 5 | "НЭТКАПИТАЛ ФИНАНС КОРПОРАЦИ ББСБ" ХХК | 42 | "АЛЛИАНС КАПИТАЛ ББСБ" ХХК |
| 6 | "ОМНИ КАПИТАЛ ББСБ" ХХК | 43 | "МАНДАЛ ДИЖИТАЛ КРЕДИТ ББСБ" ХХК |
| 7 | "ГЭРЭЛ ФИНАНС ББСБ" ХХК | 44 | "ЭНХФАЙНАНС ББСБ" ХХК |
| 8 | "БИЗНЕС-ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ" ХХК | 45 | "ДАМОА КАПИТАЛ ББСБ" ХХК |
| 9 | "ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ" ХХК | 46 | "ФИНАНС ЭНД ДЕВЕЛОПМЕНТ ОФ МАЙНИНГ ББСБ" ХХК |
| 10 | "ХӨГЖИЛ ФИНАНС ББСБ" ХХК | 47 | "ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ" ХХК |
| 11 | "ЗЭЭЛ ЭМ ЭН ПЛАТФОРМ ББСБ" ХХК | 48 | "НӨМӨР КРЕДИТ ББСБ" ХХК |
| 12 | "КРЕДИТЕХ СТМ ББСБ" ХХК | 49 | "МЭЙН СТРИТ ФИНАНС ББСБ" ХХК |
| 13 | "МОНГОЛИАНМОРТГЭЙЖ ФАНД ББСБ" ХХК | 50 | "ИНВЕСТОС ББСБ" ХХК |
| 14 | "ФРАНКФУРТ КАПИТАЛ ББСБ" ХХК | 51 | "ТЭЛМЭН ХАС ББСБ" ХХК |
| 15 | "БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК | 52 | "АНДУУД ФИНАНС ББСБ" ХХК |
| 16 | "ТАВАН БОГД ФИНАНС ББСБ" ХХК | 53 | "МОНГОЛЖИН ВЕНЧУР КАПИТАЛ ББСБ" ХХК |
| 17 | "ФИНРҮҮТ-ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК | 54 | "МОНГОЛЫН САНХҮҮГИЙН ГРУПП ББСБ" ХХК |

[†] *"Ард кредит ББСБ" ХК, "Инвескор ББСБ" ХК, "Лэндмн ББСБ" ХК, "Сэндли ББСБ" ХК, "Тандэм инвест ББСБ" ХК-ийн кодексийн хэрэгжилтийн үнэлгээ "Монголын хөрөнгийн бирж" ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн кодексийн үнэлгээний тайланд багтсан тул энэхүү зэрэглэлд оруулаагүй болно*

| | | | |
|---|---|---|---|
| 18 | "ХАТАН СУУДАЛ ИНВЕСТ ББСБ" ХХК | 55 | "АШИД ГОЛОМТ ББСБ" ХХК |
| 19 | "БСБ ФИНАНС ББСБ" ХХК | 56 | "ЭКОКАПИТАЛ ББСБ" ХХК |
| 20 | "ЖЭТФИНАНС ББСБ" ХХК | 57 | "ЭНТ КРЕДИТ ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК |
| 21 | "СЭКЮР ФИНАНС ББСБ" ХХК | 58 | "АБТС ББСБ" ХХК |
| 22 | "ИХ ИРЭЭДҮЙ КАПИТАЛ ББСБ" ХХК | 59 | "ТРАНСКАПИТАЛ ББСБ" ХХК |
| 23 | "БЭРС ФИНАНС ББСБ" ХХК | 60 | "ДАРЬ ФИНАНС ББСБ" ХХК |
| 24 | "ГОЛДЕН ХИЛЛ ПАРТНЕРС ББСБ" ХХК | 61 | "ГРИЙН ФИНТЕК ББСБ" ХХК |
| 25 | "ИНВЕСКОР ХЭТЭВЧ ББСБ" ХХК | 62 | "ЦЕНТРАЛ КАПИТАЛ ББСБ" ХХК |
| 26 | "МИКРОКРЕДИТ ББСБ" ХХК | 63 | "ЦЭГЦ ХӨРӨНГӨ ББСБ" ХХК |
| 27 | "ТРАСТ ФИНАНС ББСБ" ХХК | 64 | "ГОВЬ ФИНАНС ББСБ" ХХК |
| 28 | "ФИНКО КАПИТАЛ ББСБ" ХХК | 65 | "ЭКО КРЕДИТ ББСБ" ХХК |
| 29 | "ХАС ХААН ББСБ" ХХК | 66 | "ДЕВЕЛОПИНГ ЭНТЕРПРЕНЮРИАЛ МОНГОЛИА ББСБ" ХХК |
| 30 | "ЭКСИМ КАПИТАЛ ББСБ" ХХК | 67 | "ЭН ВИ СИ ББСБ" ХХК |
| 31 | "СЭНД ЭМ ЭН ББСБ" ХХК | 68 | "АЙ БИ И ББСБ" ХХК |
| 32 | "БҮРЭНФИНАНС ББСБ" ХХК | 69 | "БИ ЭНД ЖИ ФИНАНС ББСБ" ХХК |
| 33 | "ЖИ ЭС БИ КАПИТАЛ ББСБ" ХХК | 70 | "ЮНАЙТЕД ФИНАНС ББСБ" ХХК |
| 34 | "КИБЕРНЕТИК ББСБ" ХХК | 71 | "БУМАН ДУСАЛ ББСБ" ХХК |
| 35 | "НАНОКАПИТАЛ ББСБ" ХХК | 72 | "ГАЗАР КАПИТАЛ ПАРТНЕРС ББСБ" ХХК |
| 36 | "МАГНА ПРОФИТ ЭНД ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК | 73 | "ДЭВЖИХ НЭХИЙ ББСБ" ХХК |
| 37 | "КЛОВЕР ББСБ" ХХК | 74 | "ИХ ЭРИН КАПИТАЛ ББСБ" ХХК |

# 7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИУДЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

*ДҮРСЛЭЛ 22. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:*




*Шигтгээ 15:*

*Хөрөнгө оруулалтын менежментийн 12 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 27.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.*

*ДҮРСЛЭЛ 23. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:*




**1 хараат бус гишүүн**

**2 энгийн гишүүн**

*Шигтгээ 16:*

*Төлөөлөн удирдах зөвлөл нь 3 гишүүнтэйгээс 33.3% нь хараат бус гишүүд байна.*

*Шигтгээ 17:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 37.5% нь эмэгтэй.*

*ДҮРСЛЭЛ 24. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:*

4 — **•2023 онд хийсэн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын дундаж тоо**

92% — **•Хурлын дундаж ирц**

8 — **•Хэлэлцсэн асуудлын дундаж тоо**

*ДҮРСЛЭЛ 25. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):*




*ДҮРСЛЭЛ 26. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*




*ДҮРСЛЭЛ 27. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*



*ДҮРСЛЭЛ 28. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:*




*Шигтгээ 18:*
*Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 2–3 гишүүнтэй.*

*ДҮРСЛЭЛ 29. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:*




*Шигтгээ 19:*
*2023 оны байдлаар 33.0% нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулсан.*

*Шигтгээ 20:*
*Тайлант хугацаанд 25.0% нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.*

*ДҮРСЛЭЛ 30. ХАМГИЙН САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН КОДЕКСИЙН ЗААЛТУУД:*




## 7.1. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР БАЙР ЭЗЛҮҮЛСЭН ЗЭРЭГЛЭЛ (*Давтан үнэлгээ иргүүлсэн компанийг ногооноор тодруулав*)

| Байр | Компанийн нэрс | Байр | Компанийн нэрс |
|---|---|---|---|
| 1 | "НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 15 | "МАСТЕР ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК |
| 2 | "АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 16 | "ТИ ДИ БИ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК |
| 3 | "АШИД АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 17 | "НЭЙШНЛФАНД МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК |
| 4 | "ЭН ЖИ КОМИТИ ҮЦК" ХХК | 18 | "АВАЛОН ИНВЕСТМЕНТС ҮЦК" ХХК |
| 5 | "ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 19 | "БАТ КАПИТАЛ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК |
| 6 | "МАНДАЛ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 20 | "БИ БИ ЭС ЭЙ ҮЦК" ХХК |
| 7 | "СОД АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 21 | "ЭКСПОНЭЙШНЛ ФАНД МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК |
| 8 | "БАЛАНСЭД ГРӨҮТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 22 | "УАН ПАРТНЕРС ҮЦК" ХХК |
| 9 | "ЮНИТИ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 23 | "АЛЬФАФАЙНАНС ҮЦК" ХХК |
| 10 | "ИНВЕСКОР АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 24 | "ИХ ЧИНГИС ХААНЫ ХӨМРӨГ ҮЦК" ХХК |
| 11 | "УЛААНБААТАР АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 25 | "ТИ БИ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК |
| 12 | "РАЙНОС ЭССЭТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 26 | "ГОЛОМТ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК |
| 13 | "ОЧУН ҮЦК" ХХК | 27 | "БУМ АРД ИНВЕСТ ҮЦК" ХХК |
| 14 | "ҮҮРЭГ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | | |

## 8. "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛД ХИЙГДСЭН ТОХИРУУЛГА

"Компанийн засаглалын кодекс"-ийн үнэлгээний аргачлалд 2023 оны эцсээр дараах нэмэлт тохируулгыг хийж, үнэлгээний үр дүнд өөрчлөлт оруулсан ба 2024 оны 1-р улиралд багтаан хэрэгжилтийг нь кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайланд тусгаж, Хороонд ирүүлэхийг зохицуулалттай этгээдэд мэдэгдэв. Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороод болон төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн жилийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх;

Дээрх үүрэг хугацаандаа хэрэгжээгүй тохиолдолд кодексийн хэрэгжилтийн үнэлгээний нэгдсэн тайлангийн холбогдох үзүүлэлтээс 1 оноо хасагдахаар тохируулав.

**-oOo-**